



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 1/59

Мандалговь

Г.Бохир сорох автомашин /Сайнцагаан сум/ түүний нийлүүлэх ажлыг хүлээлцэх комисс томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын 4.3.4 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж буй “Бохир сорох автомашин /Сайнцагаан сум/” ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Н.Эрдэнэ-Очир (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга:

У.Наранцэцэг (“Оточ-Оргил” ХХК-ний захирал)

Гишүүд:

Д.Сэргэлэнбаатар (“Дундговь-Ус” ОНӨҮГ-ын ерөнхий инженер)

Э.Сүрэндолгор (“Дундговь-Ус” ОНӨҮГ-ын ерөнхий нягтлан бодогч)

Г.Эрдэнээ (“Дундговь-Ус” ОНӨҮГ-ын жолоо

2. Бохир сорох автомашин нийлүүлэх ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



4822150125